



СОЁЛЫН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ**





ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ



Зорилго 1.

Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.



ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН:



Зорилт 1.1.

Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ:

1.1.1. уран бүтээл, утга зохиолд үндэсний бахархлыг сэргээх агуулгыг тусгаж, Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзлийг сэргээнэ.

1.1.2. үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно.

1.1.3. төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааг үндэсний онцлогийг шингээсэн агуулгаар баяжуулна.

1.1.4. соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлнэ.

1.1.5. соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.



НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ



Зорилт 1.2.

Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ:

1.2.1. өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.

1.2.2. нүүдлийн соёл, иргэншлийн судалгааны төв байгуулах ажлыг эхлүүлсэн байна.

1.2.3. үндэсний сор бүтээл, брэнд, үндэсний шинэлэг бүтээл зэргийг монгол үндэсний нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээнэ.

1.2.4. хүүхдийн соёлын өв, хөгжлийн төвийг байгуулах ажлыг эхлүүлнэ.



МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ



Зорилт 1.3.

Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ:

1.3.1.бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлнэ.

1.3.2.Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ.



ЭРДЭМ СУДЛАЛ- НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ



Зорилт 1.4.

Үнэт зүйлийн болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааг салбар бүрээр хийж, нийтийн хүртээл болгоно:

1.4.1. үнэт зүйлийн судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, мэдээллийн сан бий болгож, судалгааны эргэлтэд оруулна.

1.4.2. олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлж, нийтийн хүртээл болгоно.



ДЭЛХИЙН МОНГОЛ



Зорилт 1.5.

Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлнэ:

1.5.1. Монгол хүний онцлог, давуу тал, үнэт зүйлийг тодорхойлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.

1.5.2. хилийн чанадад байгаа Монгол Улсын соёлын өвийг бүртгэх ажлыг зохион байгуулна.

1.5.3. үндэсний соёл, урлаг, зан заншил, ахуй, спорт, хоол хүнс судлалыг хөгжүүлж, өргөжүүлнэ.